



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

□ Оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрөх тухай □

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын 4.1.3, 4.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага “Баян банзай пропертис” ХХК-ийн оноосон нэрийг “Рэй менежмент групп” ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Оноосон нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралт болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгүүдийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 10 хоногийн дотор ирүүлэхийг “Рэй менежмент групп” ХХК /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН